Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2020 оны 100 тоот тушаалын
7 дугаар хавсралт

Ерөнхий боловсролын газар

2025 ОНЫ ХАГАС ЖИЛ-Н ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

| № | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэл-ийн хувь | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Эхний хагас жил | Сүүлийн хагас жил | | Өөрийн үнэлгээ | ХШҮ |
| Нэг. Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт, арга хэмжээ | | | | | | | | | |
| 1.1. | Ерөнхий боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах богино хугацааны төлөвлөгөө, арга хэмжээ | - | Ерөнхий боловсролын салбарын урт, дунд хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөгөө боловср | - | Ерөнхий боловсролын салбарын урт, дунд хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөгөө, гадаад улс, олон улсын байгууллагаас санхүүжих төслийн хэрэгжилт, ерөнхий | Монгол Улсын урт, дунд хугацаааны хөгжлийн бодлого, Засгийн газрыэн үйл ажиллагааны 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Боловсролын яамны 2025 оны үйл гүйцэтгэлийн төлөвлөгөө, Ерөнхий боловсролын газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан болон ерөнхий боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах, хүүхэд хамгаалал, сургалтын орчин нөхцөлийг сайжруулах арга хэмжээтэй холбогдох төлөвлөгөө, арга хэмжээ, чиглэл, зааврын батлуулан улсын хэмжээнд нэгдсэн зохицуулалтаар хангаж, үр дүнг тайлагнаж ажиллалаа. Тухайлбал: 1. Боловсролын сайдын 2025 оны А/188 дугаар тушаалаар “Төрөлжсөн ахлах сургуулийн талаар баримтлах чиглэл”-ийг батлууллаа 2. СӨБ, бага боловсролын сургалтын хөтөлбөр шинэчлэн боловсруулах, турших үйл ажиллагааны 2025 онд шаардагдах зардлын төсвийг Боловсролын сайдын 2025 оны 2025 оны А/28 дугаар тушаалаар батлуулан, хэрэгжилтэд дэмжлэг үзүүлж | 100% | 90% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | боловсруулах, хэрэгжилтийг удирдлага, зохицуулалтаар хангах | | уулах, батлуулах, гадаад улс, олон улсын байгууллагаас санхүүжих төслийн хэрэгжилтийг удирдлага, зохицуулалтаар хангах, ерөнхий боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах арга хэмжээний хэрэгжилтийн хувь | | боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах арга хэмжээг улсын хэмжээнд нэгдсэн зохицуулалтаар хангаж, үр дүнг тайлагнасан байна. | | ажилласнаар БСҮХ 1-5 ангийн хөтөлбөрийг ерөнхий боловсролын 27 сургуульд суурилан туршиж, төслийг боловсруууллаа. 3.Боловсролын чөлөөт бүс арга хэмжээний хүрээнд Боловсролын сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2025 оны А/109, А/92 дугаар тушаалаар хамтарсан ажлын хэсгийг байгуулж ажиллаж байна. 4. Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчид "ажил мэргэжлийн чиг баримжаа олгох" сургалт, үйл ажиллагааг төрийн болон орон нутгийн өмчийн ерөнхий боловсролын 20 сургуулийн 9 дүгээр ангид хэрэгжүүлэхээр Боловсролын сайдын 2024 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн А/123 дугаар тушаалаар шийдвэрлэж, хэрэгжилтийг хангуулан ажилалаа. 5. ”Сургуулийн соёл-суралцагчийн төлөвшлийг дэмжих үйл ажиллагааны удирдамж”-ийг Боловсролын сайдын 2025 оны А/224 дүгээр тушаалаар батлууллаа. | | |
| 1.1.1 | Дижитал шилжилт, технологийн өөрчлөл | 1,481.80 | Шинэчлэн боловсруулсан сургалтын | 533 | 327 | 229,100 | 1. Бага боловсролын сургалтын хөтөлбөрийг ЗГ-ын 2024 оны 176 дугаар тогтоолоор баталсан үзэл баримтлалд нийцүүлэн шинэчлэн боловсруулж, тохирц, нийцлийг түшиц ерөнхий боловсролын сургуулиудад шалган турших үйл ажиллагааг БСҮХ-ээс 2024 оны 11 дүгээр сараас 2025 оны 04 дүгээр сар хүртэлх хугацаанд зохион байгуулсан. Тус туршилтын хүрээнд бага боловсролын 1-2 дугаар | 100% | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | т, шинэчлэлийн сорилтыг даван туулах чадвартай, монголын түүх, хэл, соёл, үндэсний өв уламжлал, зан заншил, эх оронч хүмүүжлийг олгох боловсролын үндэсний хөтөлбөрийг хөгжүүлнэ. | | хөтөлбөрөөр хичээллэж цахим, технологийн ур чадвар эзэмшиж буй ЕБС-ийн суралцагчийн тоо | | | | ангийн Компьютерын ухааны сургалтын хөтөлбөрийн төслийг Боловсролын сайдын 2024 оны А/06 дугаар тушаалаар байгуулсан 11 хүний бүрэлдэхүүнтэй баг боловсруулж, Боловсролын сайдын 2024 оны нийслэлийн 131 дүгээр сургууль, Ховд аймгийн Жаргалант сумын 6 дугаар сургууль, Зэрэг сумын ерөнхий боловсролын сургуульд тус тус түшиглэн зохион байгууллаа. Тус туршилтын хөтөлбөрийг дээрх 3 сургуулийн 1-5 дугаар ангийн нийт 15 бүлгийн 518 суралцагчийг хамруулан зохион байгуулсан. 2. Бага боловсролын хөтөлбөрийн шинэчлэлийн хүрээнд 1-2 дугаар ангид "Минии Монгол", 3-5 дугаар ангид ""Миний эх орон" сургалтын хөтөлбөрийг боловсруулан туршсан бөгөөд тус хөтөлбөр нь үндэсний болон дэлхийн өв соёлд суралцах, Монгол хүний эрхэмлэх үнэт зүйл, үндэсний соёл, өв уламжлалаа мэдэж, бахархах, баримталж хэвшихэд чиглэсэн агуулгатай. 3. Сургалтын хөтөлбөрийн туршилтыг үр дүнтэй зохион байгуулах санхүүжилтийн нөхцөлийг бүрдүүлэн Боловсролын сайдын 2025 оны 01 дүгээр сарын 28-ны "Түшиц цэцэрлэг, ЕБС-ийн суурь хувьсах зардлыг нэмэгдүүлэн санхүүжүүлэх, ажлын хөлс олгох тухай" А/33 дугаар тушаалыг боловсруулан батлуулж, мөн сайдын 2025 оны А/11 дүгээр тушаалаар СӨБ, бага боловсролын сургалтын шинэчлэн боловсруулж буй хөтөлбөр, төлөвлөгөөг улсын хэмжээнд хэрэгжүүлэх бэлэн байдлыг хангах ажлын хэсгийг байгуулж, БЯ-ны ТНБД ахлан ажиллаж байна. Сургалтын хөтөлбөрийн гол шинэчлэл нь арга зүйн шинэчлэл байх бөгөөд "Монголын түүх, хэл, соёл, үндэсний өв уламжлал, зан заншил, эх оронч хүмүүжлийг олгох нийтлэг агуулга", англи хэл, кодчилол, роботик, хиймэл оюуны анхан шатны мэдлэг, чадвар эзэмжшүүлэх агуулгыг тусган боловсруулж, туршсан.<br>Хавсралт: 5 файл | | |
| 1.1.2 | Бүх түвшний боловсролын сургалтын хөтөлбөрт Монголы | 5,927.30 | Монголын түүх, хэл, соёл, үндэсний өв уламжлал, зан заншил, | - | - | 8 | Боловсролын сайдын 2024 оны "Турш"А/57 дугаар тушаалын дагуу бага боловсролын сургалтын хөтөлбөрийг ЗГ-ын 2024 оны 176 дугаар тогтоолоор баталсан үзэл баримтлалд нийцүүлэн шинэчлэн боловсруулж, тохирц, нийцлийг түшиц 27 сургуульд шалган туршсан. Туршилтын үр дүн болон экспертийн дүгнэлтийг тусган боловсруулсан 1-2 дугаар ангийн Монгол хэл, математик, байгалийн шинжлэл, зураг урлал, хөгжим, биеийн тамир, Миний Монгол, Эрүүл мэнд, Компьютерын ухаан, үндэсний цөөнхийн суралцагчдад зориулсан Казах хэл, Тува хэл, ялгаатай хэрэгцээтэй суралцагчдад зориулсан | 100% | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | н түүх, хэл, соёл, үндэсний өв уламжлал, зан заншил, эх оронч хүмүүжлийг олгох нийтлэг агуулгыг тусгаж хэрэгжүүлнэ. | | эх оронч хүмүүжлийг олгох нийтлэг агуулгыг тусган шинэчлэн боловсруулж, тухайн онд батласан хөтөлбөрийн тоо | | | | Нийгэм ахуйн баримжаа гэсэн нийт 12 төрлийн сургалтын хөтөлбөр, ерөнхий боловсролын сургуулийн 1-2 дугаар ангийн сургалтын төлөвлөгөөний төслийг Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 10.6-д заасанчлан Мэргэжлийн зөвлөлийн дүгнэлт, зөвлөмж авахаар Боловсролын яаманд 2024 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн 133 дугаар албан бичгээр ирүүлсэн. Ерөнхий боловсролын мэргэжлийн зөвлөлийн онлайн хурлыг 2025 оны 05 дугаар сарын 14-ний өдөр зохион байгуулж, хөтөлбөрийн бүтэц, боловсруулсан үндэслэлийн талаар мэдээлэл өгөв. Мэргэжлийн зөвлөлийн хурлаар Сургуулийн өмнөх болон бага боловсролын сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлал, 1-2 дугаар ангийн сургалтын хөтөлбөрийг шинэчлэн боловсруулсан үйл явц, үр дүн, хөтөлбөрийн онцлог, бүтцийн талаар мэдээлэл өглөө. Шинэчлэн боловсруулж буй Миний монгол судлагдахууны хөтөлбөрийн агуулга,арга зүй нь Монголын түүх, хэл, соёл, үндэсний өв уламжлал, зан заншил, эх оронч хүмүүжлийг олгоход бүхэлдээ чиглэж байгаа бөгөөд бусад судлагдахууны хөтөлбөрөөр эзэмших ерөнхий чадварт Монголын түүх, хэл, соёл, үндэсний өв уламжлал, зан заншил, эх оронч үзэл хандлага төлөвшүүлэх суралцахуйн үйл ажиллагаа, арга зүйн шийдэл, үнэлгээний шалгуурыг интеграци байдлаар тусган боловсруулсан. Мэргэжлийн зөвлөлийн гишүүдэд хөтөлбөр, төлөвлөгөөг ТНБД-ын 2025 оны 05 дугаар сарын 23-ны 2/2268 албан тоотоор хүргүүлж, санал, зөвлөмж авах үйл ажиллагааг зохион байгуулж байна. | | |
| 1.1.3 | Ерөнхий боловсролын сургуулийн байгалийн ухаан, мэдээллийн технологи, биеийн тамир, эрүүл | 4,445.50 | Шинэчилсэн сургалтын хөтөлбөрөөр хичээллэсэн 1-5 дугаар ангийн суралцагч тоо | - | 4,576 | 381,000 | Сургуулийн өмнөх, бага боловсролын сургалтын хөтөлбөрийн шинэчлэлийн хүрээнд Боловсролын сайдын 2024 оны "Туршилтын сургалтын төлөвлөгөө батлах тухай" А/57 дугаар тушаалд заасны дагуу бага боловсролын биеийн тамир, байгалийн шинжлэлийн сургалтын хөтөлбөрийн төсөл, бага ангид хүүхэд хөгжүүлэх цагаар хэрэгжүүлэх эрүүл мэндийн агуулга бүхий модуль боловсруулан турших үйл ажиллагааг 2024-2025 оны хичээлийн жилийн 1-2 дугаар улиралд түшиц 15 сургуульд хэрэгжүүлсэн. Тус туршилтын хүрээнд Ерөнхий боловсролын сургуулиудад түшиглэн зохион байгуулж дууссан. Тус туршилтын сургалтын хөтөлбөрт 2025-2026 оны хичээлийн жилд Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнгийн түшиц 26 сургуулийн 4576 суралцагч хамрагдсан. Бага ангийн суралцагчдын эрүүл мэндийн боловсролын дэмжих агуулгыг Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнгээс ЕБС-ийн бага ангийн сургалтын төлөвлөгөөний төсөлд тусган ирүүлсэн бөгөөд 1-2 | 100% | 90% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | мэндийн сургалтын хөтөлбөрийг шинэчилж хэрэгжүүлнэ. | | | | | | дугаар ангийн эрүүл мэндийн сургалтын хөтөлбөрийг боловсруулан,эцэслэж, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 10.6-д заасанчлан Боловсролын ерөнхий хуулийн 23.3-т заасан Мэргэжлийн зөвлөлийн санал, дүгнэлтийг авахаар хүргүүлээд байна. | | |
| 1.1.5 | Ерөнхий боловсролын сургуулийн байгалийн ухаан, мэдээллийн технологи, биеийн тамир, эрүүл мэндийн багш нарт сургалтын шинэчилсэн хөтөлбөрийг хэрэгжүүлэх сургалт зохион байгуулн | 1,800.0 | Бага ангийн түмэн бодис, компьютерийн ухаан, биеийн тамир, эрүүл мэндийн шинэчилсэн сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх сургалтад хамрагдсан багш нарын эзлэх хувь | 0.9 | 80 | 100 | Боловсролын сайдын 2025 оны А/25 дугаар тушаалаар баталсан журмын дагуу зохион байгуулсан бага боловсролын болон биеийн тамир, эрүүл мэндийн багш нарын мэргэжил дээшлүүлэх үндсэн сургалтын хөтөлбөрт шинэчилссэн сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлал, шинэчилсэн хөтөлбөрийн бүтэц, онцлогийн талаар агуулга тусган хэрэгжүүлсэн. Боловсролын сайдын 2025 оны А/101 дүгээр тушаалаар баталсан Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын төлөвлөгөө, хөтөлбөр, сурах бичгийг шинэчлэх, тохирц, нийцлийг шалгах, хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө (2025-2030 он)-нд тодорхой шалтгаануудын улмаас өөрчлөлт орохоор болсон тул Бага ангийн түмэн бодис, компьютерийн ухаан, биеийн тамир, эрүүл мэндийн шинэчилсэн сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх сургалтыг нийт багш нарт 2025-2026 оны хичээлийн жилд зохион байгуулна. | 50% | 50% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | а. | | | | | | | | |
| 1. 1. 6 | Суралцагчдын унших чадварыг нэмэгдүүлэх зорилгоор ерөнхий боловсролын сургуульд чөлөөт уншлагын бичил номын сангийн загвар бий болгоно. | 300.0 | Чөлөөт уншлагын бичил номын сангийн загвар бий болгосон сургуулийн тоо | - | - | 4 | Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчдын суурь унших чадварыг сайжруулах, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, ном унших соёлыг түгээн дэлгэрүүлэх зорилгоор ерөнхий боловсролын сургууль, ерөнхий боловсролын сургуулийн дотуур байр, насан туршийн суралцахуйн төв, нийслэлийн зарим дүүргийн хороодын иргэний танхимд бичил номын сан байгуулах чиглэлээр судалж байна. Зарим хороодын иргэний танхимын байрыг очиж үзэн бичил номын санд тавих номын тавиур, сандал ширээ хийх зардлын тооцооллыг гаргасан. Мөн сургууль, дотуур байр, хороо хаана ч тавих боломжтой номын сангийн өөртөө үйлчлэх киоск, 24 цагаар өөртөө үйлчлэх ухаалаг номын сангийн шүүгээ зэргийг судалж Боловсролын ерөнхий газрын холбогдох мэргэжилтэн, дарга нартай уулзалт зохион байгуулж санал солилцсон. Бичил номын сан байгуулах ажил 2025 оны сүүлийн хагас жилд хийгдэнэ.<br>Хавсралт: 2 файл | 100% | 90% |
| 1. 1. 8 | Ерөнхий боловсролд "Цөөн хүүхэдтэй анги", "Гэрт ойр сургууль-хамгийн сайн сургууль" арга хэмжээг хэрэгжүү | - | Нэг ээлжээр хичээллэж байгаа ерөнхий боловсролын сургуулийн эзлэх хувь Стандартын шаардлага | 50.2 76.5 (Нийслэл), 97.0 (Аймаг) 40.0 | 50.2 76.5 (Нийслэл), 97.0 (Аймаг) 40.0 | 52, 78, 98, 50 | Боловсролын сайдын 2025 оны А/113 дугаар тушаалаар Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт заасан “бүлэг дүүргэлтийг стандартын түвшинд хүргэх "Нэг ээлж, цөөн хүүхэдтэй анги", "Гэрт ойр сургууль-хамгийн сайн сургууль" арга хэмжээг хэрэгжүүлэх, нийслэлийн ерөнхий боловсролын сургуулийн хүртээмжийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд хүн амын төвлөрөл ихтэй хороолол, хотхонд бага сургууль байгуулах ажлыг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллах ажлын хэсгийг байгуулсан. Ажлын хэсгийн гишүүд хүн амын төвлөрөл ихтэй, төрийн болон орон нутгийн өмчийн сургуульгүй хороолол, хотхон, бага ангийн суралцагчдын судалгаа, түрээслэх иргэн, хуулийн этгээдийн өмчлөлд байгаа бага сургуулийн зориулалтаар ашиглах боломжтой барилга, эсхүл хороолол, хотхоны зохих стандарт, шаардлага хангасан орон сууцны барилгын нэг давхар, үйлчилгээний талбайн судалгааг хийсэн. Хотхоны бага сургууль байгуулах асуудлаар ажлын хэсэг 3 удаа | 90% | 90% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | лнэ. | | хангасан бүлэг дүүргэлттэй сургуулийн бүлгийн хувь (нийслэл, аймаг) Орчны стандартын шаардлага хангасан сургуулийн эзлэх хувь | | | | хуралдсан. Ажлын хэсэг Боловсролын сайдын тушаалаар "Хотхоны бага сургуулийн талаар баримтлах чиглэл"-ийг боловсруулан батлуулахаар шийдвэрлэсэн. "Хотхоны бага сургуулийн талаар баримтлах чиглэл"-ийн төслийг боловсруулж газар, хэлтсийн дарга нар албан бичиг хэргийн системээр хянаж байна. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд нийслэлийн хүн амын төвлөрөл ихтэй, төрийн болон орон нутгийн өмчийн сургуульгүй, хороолол хотхонд "Хотхоны бага сургууль" байгуулснаар бага ангийн суралцагчдыг гэрт ойр сургуульд нэг ээлжид хичээллэх боломж бүрдэж, бага ангийн бүлэг дүүргэлт багасна.<br>Хавсралт: 1 файл | | |
| 1.1.9 | Ерөнхий боловсролын сургуулийн суудлын тоог үе шаттай нэмэгдүүлж, сургуулиудад бүтцийн дахин төлөвлөлт хийнэ. | - | Шинээр нэмэгдсэн суудлын тоо Бүтцийн дахин төлөвлөлт хийсэн сургуулийн тоо | - | - | 22,160 -- | Ерөнхий боловсролын сургуулийн бүтцийн дахин төлөвлөлтийн онол, арга зүйн талаар олон улсын судалгааны материалтай танилцаж, аймаг, суманд байршилтай сургуулийн хэмжээний өнөөгийн байдлын тооцоолол хийлээ. Сургуулийн хэмжээ олон талаар сургалтын үр дүнд нөлөөлдөг бөгөөд суралцагчийн тоо нэмэгдэх тусам тодорхой эдийн засгийн зардал буурч, сургуулийн хэмжээ хэт томроход захиргааны бүтэц төвөгтэй болж үр ашиг буурдаг гэж үздэг. Иймд бага сургуулийг 300-500 суралцагчтай, бусад түвшинд, нэн ялангуяа ахлах сургуулийг 600-900 суралцагчтай байх нь тохиромжтой хэмээн үзсэн үр дүнг олон улсын судалгаанаас харж болохоор байна. ЭЗХАХБ-ын орнуудад 300 болон түүнээс цөөн суралцагчтай бол “жижиг сургууль” гэж үздэг юм байна. Харин дунд сургууль 660 орчим, ахлах сургууль 920 орчим суралцагчтай бол “дундаж хэмжээтэй” сургууль гэж үзжээ. Мөн боловсролын үр дүнд нөлөөлөх хүчин зүйлийн судалгаанд сургуулийн хэмжээ сургалтын үр дүнд эерэгээр нөлөөлөх боломжит хэмжээг 680-960 гэж тогтоосон судалгаа бий. Манай улсын 339 сум, дүүргийн хэмжээнд 2024-2025 оны хичээлийн жилд төрийн болон орон нутгийн өмчийн ерөнхий боловсролын 705 сургууль сургалтын үйл ажиллагаа эрхэлж байгаа бөгөөд тэдгээрийн 76.5 хувь нь орон нутагт байна. | 70 % | 70 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Аймаг, суманд байршилтай нийт сургуулийн 261 буюу 48.4 хувь нь 500-аас доош суралцагчтай, 133 буюу 24.7 хувь нь 500-897 суралцагчтай, 56 буюу 10.4 хувь нь 904-996 суралцагчтай, 40 буюу 7.4 хувь нь 1200-1597 суралцагчтай, 49 буюу 9 хувь нь 1600-5000 суралцагчтай байна. Манай улсын 330 сумын 72.1 хувь (238)-д нь 1-12 дугаар ангитай бүрэн дунд сургууль сургалтын үйл ажиллагаа эрхэлж байгаа бөгөөд тэдгээрийн 217 буюу 91.1 хувь нь суманд байна. Иймээс суманд байршилтай бүрэн дунд сургуулийн бүтцийг (i) хүн амын тооны өсөлт, (ii) ээлжийн коэффицент, (iii) бүлэг дүүргэлт; (iv) дотоод үр ашиг; (v) сургалтын чанар, (vi) багшийн чанар, (vii) сургалтын орчин, нөөцийн хүртээмж, (viii) төсөв түүний үр ашиг гэсэн үзүүлэлтээр нэмж тооцох шаардлага үүссэн. Хавсралт: 1 файл | | |
| 1.1.10 | Төрөлжсөн ахлах сургуулийн талаарх бодлогын чиглэл батлуулж, хэрэгжилтэд дэмжлэг үзүүлнэ. | 960.0 | Төрөлжсөн ахлах сургуулийн бодлогын чиглэлийн төсөл Төрөлжсөн ахлах сургуулийн тоо | - | - | 4 | Боловсролын сайдын 2025 оны А/188 дугаар тушаалаар “Төрөлжсөн ахлах сургуулийн талаар баримтлах чиглэл”-ийг батлууллаа. Төрөлжсөн ахлах сургууль нь 10-12 дугаар ангитай байх бөгөөд суралцагчдад бүрэн дунд боловсрол эзэмшүүлэхийн зэрэгцээ тэднийг дараагийн түвшний боловсрол болон ажил мэргэжлээ сонгоход бэлтгэх, мэргэжлийн эрх олгох/мэргэжлийн сургалт, үйл ажиллагаа зохион байгуулах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Ахлах сургууль нь технологи, хөдөө аж ахуй, эрүүл мэнд-сувилахуй, үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээ, байгалийн ухаан, математик, нийгэм-хүмүүнлэг, соёл урлаг, спортын чиглэлээр төрөлжинө. Харин мэргэжлийн эрх олгох сургалтыг технологи, хөдөө аж ахуй, эрүүл мэнд-сувилахуй, үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээ гэсэн чиглэлээс сонгон зохион байгуулж, төгсөгчдөд чадамжийн гэрчилгээ олгох бодлого баримтлахаар заасан. Төрөлжсөн ахлах сургууль нь их сургууль, коллежитой хамтарсан хөтөлбөр хэрэгжүүлэх, эсхүл их сургууль, коллеж, мэргэжлийн боловсролын сургуулийн мэргэжлийн суурь хичээлийг сонгон судлах хичээлээр суралцагч судалж болох эрхийг нээж өгсөн. Хавсралт: 1 файл | 100% | 100% |
| 1.1.11 | Ерөнхий боловсролын сургууль | 1,481.30,649,570. | Кодчилол, роботик болон | 0 | 327 | 79,000 382,100 | Сургуулийн өмнөх, бага боловсролын сургалтын хөтөлбөрийг ЗГ-ын 2024 оны 176 дугаар тогтоолоор баталсан үзэл баримтлалд нийцүүлэн шинэчлэн боловсруулах хүрээнд Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнгээс 1-5 дугаар ангийн "Компьютерийн ухаан" сургалтын | 100% | 90% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | д кодчилол, роботик болон хиймэл оюуны ур чадварыг хөгжүүлэх сургалтын хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлнэ. | 00 | хиймэл оюуны ур чадварыг хөгжүүлэх сургалтын хөтөлбөрөөр суралцсан суралцагчийн тоо, Шинэчлэн боловсруулсан сургалтын хөтөлбөрт хамрагдсан суралцагчийн тоо | | | | хөтөлбөрийн төслийг боловсруулж, тохирц, нийцлийг түшиц цэцэрлэг, ЕБС-д шалган турших үйл ажиллагааг 2024 оны 11 дүгээр сараас 2025 оны 04 дүгээр сард зохион байгуулсан. БСҮХ-ээс 2025 Туршилтын үр дүн болон экспертийн санал, зөвлөмжийг тусган сургалтын хөтөлбөрийн төслийг сайжруулж, 1-2 дугаар ангийн "Компьютерийн ухаан" сургалтын хөтөлбөрийн төслийг Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 10.6-д заасанчлан Боловсролын ерөнхий хуулийн 23.3-т заасан Мэргэжлийн зөвлөлийн дүгнэлт, зөвлөмжийг авахаар Боловсролын яаманд 2024 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн 133 дугаар албан бичгээр ирүүлсэн. Үүнтэй холбогдуулан Боловсролын сайдын 2025 оны "Бүрэлдэхүүн шинэчилж, журамд өөрчлөлт оруулах тухай"А/191 дүгээр тушаалын хоёрдугаар хавсралтаар баталсан Ерөнхий боловсролын мэргэжлийн зөвлөлийн онлайн хурлыг 2025 оны 05 дугаар сарын 14-ний өдөр онлайнаар зохион байгуулж, санал зөвлөмж авахаар хүргүүлээд байна. Бага боловсролын Компьютерийн ухаан сургалтын хөтөлбөр нь суралцагчид технологи, программ ашиглан бүтээлч сэтгэлгээгээ хөгжүүлэн, биет болон биет бус тооцооллоор дамжуулан кодчилолд суралцахад чиглэх бөгөөд 1. Компьютерийн цагаан толгой, 2. Тооцоолох сэтгэлгээ, 3. Өгөгдөл ба хиймэл оюун гэсэн үндсэн бүтэцтэй байна. | | |
| 1.1.12 | Ерөнхий боловсролын 3 дугаар ангиас англи хэлний сургалтыг зохион | 6,719.80 | Англи хэлний Пийрсон сургалтын хөтөлбөрөөр хичээллэсэн суралцаг | 263,251 | 12000 | 466,650 | 1. Боловсролын сайдын 2024 оны А/68 тушаалын дагуу ерөнхий боловсролын 104 сургуулийн 3, 4 дүгээр ангид PEARSON ENGLISH хөтөлбөрийг 2024-2025 оны хичээлийн жилд туршин хэрэгжүүллээ. 2. Пийрсон англи хэлний хөтөлбөрт төрийн өмчийн ерөнхий боловсролын сургуулийн 5-7 дугаар ангийн 202951, туршилтын 104 сургуулийн 3-4 дүгээр ангийн 37,161, ерөнхий боловсролын 38 сургуулийн 8-11 дүгээр ангийн 19960, Мэдлэ цахим сургуулийн 10-12 дугаар ангийн 730 суралцагч, нийт 263,802 суралцагч хамрагдаж байна. 3. 2025-2026 оны хичээлийн жилээс эхлэн төрийн болон орон нутгийн өмчийн нийт ЕБС-ийн 3 дугаар ангиас оруулах зорилгоор багшийн хүрэлцээ, хангамжийн | 100% | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | байгуулна. | | чийн тоо | | | | судалгааг аймаг, нийслэлийн БГ-уудаас авч нэгтгэхэд бага ангид англи хэл зааж эхлэхтэй холбогдон улсын хэмжээнд 900 орчим багшийн дутагдал үүсэхээр байна. Мөн БСҮХ-ээс авсан асуулга судалгаагаар бага боловсролын багш нарын 40 орчим хувь нь бага ангийн түвшинд англи хэл заах арга зүй болон хэлний чадвараа сайжруулах сургалтад хамрагдаж, дэмжлэг авсан тохиолдолд 3-4 дүгээр ангид англи хэл зааж чадна гэсэн хариу өгсөн байна. Энэ жил багш бэлтгэдэг нийт их, дээд сургуулийг 312 оюутан төгсөна. 2025-2026 оны хичээлийн жилээс 3-4 дүгээр ангид англи хэл заах багш нарын нөөцийг бүрдүүлэх шийдлийн хувилбаруудыг 2025 оны 05 сарын 19-ний өдрийн сайдын шуурхай хуралд танилцуулсан бөгөөд аймаг, нийслэлийн Боловсролын газруудтай онлайн уулзалтыг 2025 оны 06 сарын 03 ны өдөр зохион байгуулж, англи хэлний хичээлийн цагийн төлөвлөлт, багшаар хангах сургуулийн тооцоолол, төлөвлөлтийг хийх аргачал, чиглэлийг өгч ажиллалаа. Бага ангид англи хэл заах багш нарт зориулсан сургалтыг 2025 оны 06-08 дугаар сард танхим, онлайн хэлбэрээр хослуулан зохион байгуулах бэлтгэл ажлыг БЯ-ны ЕБГ, БЕГ, АЙ И Ди Си ХХК хамтран зохион байгуулж байна. ЕБС-ийн 3-8 дугаар ангид Пийрсон хөтөлбөрөөр англи хэл заах багшийн болон суралцагчийн ном/сурах бичиг-ийг монгол хүүхдэд зориулсан агуулгаар баяжуулан, тохируулсан бөгөөд 2025 оны 06-07 дугаар сард хэвлүүлэхэд бэлэн болсон. | | |
| 1.1.14 | Суурь боловсролын сургалтын хөтөлбөрийг өндөр технологи, байгаль орчин, сансар судлалын мэдлэг, | 444.50 | Дурдсан агуулгаар баяжуулж шинэчилсэн сургалтын хөтөлбөрөөр суралцсан суралцагчийн тоо | - | - | 4,576 | Сургуулийн өмнөх, бага, боловсролын сургалтын хөтөлбөр шинэчлэн боловсруулах, сурах бичгийн эх зохиох, хянах, туршиж сайжруулах, суурь боловсролын сургалтын хөтөлбөр шинэчлэн боловсруулах, хянах, турших үйл ажиллагааны 2025 онд шаардагдах зардлын төсвийг Боловсролын сайдын тушаалын 2025 оны 2025 оны А/28 дугаар тушаалаар батлуулан БСҮХ- д хүргүүлснээр Суурь боловсролын сургалтын хөтөлбөрийг боловсруулах үйл ажиллагааны санхүүгийн боломж бүрдсэн. Суурь боловсролын сургалтын хөтөлбөрийг 2025 оны 2 дугаар хагас жилээс эхлэн боловсруулж эхэлнэ. | 100% | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | мэдээллээр баяжуулан шинэчилнэ. | | | | | | | | |
| 1.1.15 | "Боловсролын чөлөөт бүс" арга хэмжээг хэрэгжүүлнэ. | 240.0 | Арга хэмжээний хэрэгжилтийн хувь | 0 | 10 | 25 | Боловсролын чөлөөт бүс арга хэмжээний хүрээнд Боловсролын сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2025 оны А/109, А/92 дугаар тушаалаар хамтарсан ажлын хэсгийг байгуулж. тус ажлын хэсгийн нарийн бичгийн даргаар ажиллаж байна. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд Боловсролын яам, Боловсролын ерөнхий газар, Хууль зүй, дотоод хэргийн яам, Хил хамгаалах ерөнхий газар, ХААН банк, Нэгдсэн үндэстний байгууллагын Хүүхдийн сангийн ажилтан, албан хаагчид хамтран ажиллаж байна. Ажлын хэсэг Хилийн застав болон хил орчмын алслагдсан бүс нутгийн малчин иргэдийн хүүхэд гэрт ойр бага боловсрол эзэмших боломж бүрдүүлэх зорилгоор Дорнод, Сүхбаатар, Говь-Алтай, Баян-Өлгий, Ховд, Увс аймгуудын хилийн застав, сумын ерөнхий боловсролын сургуулийн нөхцөл байдалтай танилцан багийн бага сургууль ,цэцэрлэгийн цогцолбор байгуулах хэрэгцээг судалж, сургууль цэцэрлэгийн цогцолборын барилгын зураг төсөл, төсвийн төсөл боловсруулсан бөгөөд ХААН банк нийгмийн хариуцлагын хүрээнд хувийн хэвшлийн байгууллагуудыг манлайлан санхүүжилт, хөрөнгө оруулалт босгох, 2025-2026 онд Увс аймгийн Давст сумын Боршоо баг, Хөвсгөл аймгийн Рэнчинлхүмбэ сумын Хөндий баг, Төв аймгийн Батсүмбэр сумын Үдлэг баг гэсэн 3 байршилд багийн бага сургууль, цэцэрлэгийн барилга барих, Ховд аймгийн Үенч сумын ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны засварт тус тус санхүүжилт хийх саналыг ХААН банкны зүгээс танилцууллаа. Бусад шаардлагатай байршилд багийн бага сургууль байгуулах боломжийг нэмэгдүүлэх зорилгоор "Нэг баг-нэг сургууль" төслийг ХААН банкнаас санаачлан хувийн хэвшлийн байгууллагуудыг манлайлан уриалах зорилгоор 2025 оны 06 дугаар сард оролцогч талуудын уулзалт, өдөрлөгийг зохион байгуулахаар төлөвлөсөн. Төслийн хүрээнд санхүүжилтийг НҮБ-ын Хүүхдийн санд төвлөрүүлэн, зарцуулах, хяналт тавих, Боловсролын яамнаас багийн бага сургуульд тоног төхөөрөмж нийлүүлж, сургалтын тогтвортой үйл ажиллагааг хангахаар тус тус төлөвлөж байна. | 100% | 90% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1.1.16 | Сургуульд суурилсан эрүүл мэндийн үйлчилгээ, эрт илрүүлэг зохион байгуулна. | 300.0 | Эрүүл мэндийн үзлэгт хамрагдсан 6 настай хүүхдийн нас, эзлэх хувь | 6 настай - 75.2 /2023/, | 40 | 80 | Ерөнхий боловсролын сургуулийн 1 дүгээр ангийн суралцагчдын нүдний эмгэгийн эрт илрүүлгийн үзлэгийг зохион байгуулахад шаардлагатай харааны хэрэглэгдэхүүнийг худалдан авахад шаардагдах зардал болох 300,000,000 сая төгрөгийг Боловсролын сайдын тушаалаар баталж, удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллалаа. Түүнчлэн Боловсролын яам, Боловсролын ерөнхий газрын зохион байгуулалттайгаар Эрүүл мэндийн яам, Орбис олон улсын байгууллагатай хамтран "Хараа шалгах аргачлал"-ын 5 удаагийн сургалтад нийслэлийн төрийн болон төрийн бус өмчийн ерөнхий боловсролын сургуулийн 300 эмч, орон нутгийн боловсролын болон эрүүл мэндийн газрын мэргэжилтнүүд, нүдний эмч нарын төлөөлөл нийт 92 оролцогчийг сургагч багшаар бэлтгэн 21 аймгийн хамтарсан баг аймаг бүрт сургалт зохион байгуулж, чадавхжуулсан. “Сургуульд суурилсан эрт илрүүлгийн тогтолцоог сайжруулах бодлого”-ын хүрээнд нийслэлийн Ерөнхий боловсролын сургуулийн нэгдүгээр анги буюу 6 настны нүд, шүд, зүрхний эрт илрүүлгийн үзлэг 2024 оны 4 дүгээр улирлаас эхэлж, нийт 69,127 суралцагч буюу нийт 6 настангуудын 94,8 хувь нь хамрагдсан байна. Үүнээс зүрхний үзлэгт 55,482 суралцагч хамрагдсанаас 10,487 суралцагчийг илрүүлж, дараагийн шатлалд 5,225 суралцагчийг, нүдний үзлэгт 50,160 суралцагч хамрагдсанаас 9,098 суралцагчийг илрүүлж, дараагийн шатлалд 1037 суралцагчийг, шүдний үзлэгт 59,308 суралцагч хамрагдсанаас 48,025 суралцагчийг илрүүлж, дараагийн шатлалд 24,474 суралцагчийг тус тус шилжүүлэн эмчлүүлсэн байна. Нүдний харааны үзлэгт хамрагдсан хүүхдүүдийн 4,290 нь холын хараа тэнцээгүй, 1,648 нь ойрын хараа тэнцээгүй, 2,770 нь стерео хараа тэнцээгүй байсан бол 5,797 хүүхэд нарийн мэргэжлийн эмчид үзүүлэх шаардлагатай гэсэн үр дүн гарсан. Холбогдох линкийг оруулав. https://eruulhuuhed.mn/mainDashboard/3 Хавсралт: 1 файл | 100% | 100% |
| 1.1.17 | Ерөнхий боловсролын бүх сургуулийг эмчтэй болгоно. | 470.0 | Эмчтэй сургуулийн тоо | 537 | 537 | 565 | Төрийн болон орон нутгийн өмчийн ерөнхий боловсролын сургуульд Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд, Сангийн сайдын хамтарсан 2018 оны “Орон тооны жишиг норматив батлах тухай” А/024/11 дүгээр тушаалаар баталсан орон тооны жишиг нормативыг мөрдөж байна. Тус нормативын дагуу 480 аас доош суралцагчтай ЕБС-д эмч ажиллахгүй байхаар зохицуулсан байдаг тул Боловсролын ерөнхий хуулийн 6.7-д "Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль нь суралцагчийн ялгаатай хэрэгцээнээс хамаарч энэ хуулийн 14.1, 14.3-т | 70% | 70% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | зааснаас гадна тусгай хэрэгцээт боловсролын багш, багшийн туслах, эмч, сувилагч, сэргээх болон нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэх мэргэжлийн ажилтантай байна."гэсэнд нийцүүлэн “Төрийн болон орон нутгийн өмчийн ерөнхий боловсролын сургуулийн багшаас бусад, захиргааны удирдлага, ажилтны орон тооны хязгаарын жишиг нормативыг хэрэгжүүлэх заавар”-ын төслийг боловсруулан Боловсролын сайд, Сангийн сайд хамтран батлахаар Сангийн яаманд Боловсролын сайдын 2025 оны 04 дүгээр сарын 24 ний өдрийн 1/1712 дугаар албан бичгээр хүргүүлсэн бөгөөд тус яамнаас ирсэн саналыг тусган дахин боловсруулж, Боловсролын сайдын 2025 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн 1/2563 дугаар албан бичгээр хүргүүллээ. Орон тооны жишиг хязгаарын саналд ерөнхий боловсролын сургууль тус бүр эмчтэй байхаар тусгасан. 2024-2025 оны хичээлийн жилийн статистик мэдээгээр улсын хэмжээнд 885 ЕБС-д эмч 537, хүүхдийн сувилагч 8, сэргээн засалч, нөхөн сэргээх мэргэжлийн ажилтан 7, согог зүйч 2, хүүхдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх ажилтан нийт 554 ажиллаж байна.<br>Хавсралт: 2 файл | | |
| 1.1.18 | Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны стандарт, техникийн зохицуулалтыг шинэчлэн батлуулж, орны тоог үе шаттай | 28,200.00 7.50 | Хүсэлт гаргасан суралцагчдаас дотуур байранд хамрагдсан суралцагчийн хувь, Стандарт, техникийн зохицуулалтын шаардлага | 95.5 25 30 | 96 25 25 | 96 35 50 | Ерөнхий боловсролын салбарын 2024-2025 оны хичээлийн жилийн жилийн статистикийн мэдээгээр ЕБС-ийн 415 сургууль дотуур байртай бөгөөд дотуур байрны нийт 463 барилгын 400 /86,3%/, стандартын шаардлага хангасан байна. Эдгээр дотуур байранд амьдрах хүсэлт гаргасан 35,817 хүүхдийн 35,486 /99.08%/ нь дотуур байранд амьдарч, эдгээрээс 27,359 нь малчдын хүүхэд байна. ЕБС-ийн дотуур байранд нийт 612 багш, 6 настны туслах багш 340 ажиллаж байна. Боловсролын сайдын 2025 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн “Журам батлах тухай” А/25 дугаар тушаалын хоёрдугаар хавсралтаар батлагдсан “Хүүхдийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багш, удирдах ажилтны мэргэжил дээшлүүлэх журам”-ын хүрээнд эхний жилдээ ажиллаж буй багш, удирдах ажилтан, дотуур байрын багш нар үндсэн сургалтад хамрагдахгүй болсон тул төсөл хөтөлбөрийн болон бусад төрлийн сургалт, хөгжлийн үйл ажиллагаанд дотуур байрны багшийг хамруулах боломж, нөхцөлийг бүрдүүлэх шааардлагатай байна. | 30 % | 30 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | нэмэгдүүлж, багш, хүний нөөцийн чадавхжуулж, суралцагчид ээлтэй үйлчилгээг нэвтрүүлнэ. | | хангасан дотуур байрны эзлэх хувь Чадавхжуулах сургалт, үйл ажиллагаанд хамрагдсан дотуур байрны багшийн тоо | | | | | | |
| 1.1.21 | Дунд, ахлах ангийн суралцагчдад ажил мэргэжлийн чиг баримжаа олгох сургалт, үйл ажиллагааг зохион байгуулна. | 300.0 | Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох сургалт, үйл ажиллагаанд хамрагдсан 8-12 дугаар ангийн суралцагчдын эзлэх хувь | - | 5 | 20 | Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчид ажил мэргэжлийн чиг баримжаатай болох, түүнд нийцүүлэн ахлах ангийн хичээл сонголт хийхэд дэмжлэг үзүүлэх зорилготой "ажил мэргэжлийн чиг баримжаа олгох" сургалт, үйл ажиллагааг төрийн болон орон нутгийн өмчийн ерөнхий боловсролын 20 сургуулийн 9 дүгээр ангийн суралцагчдыг хамруулан 2024-2025 оны хичээлийн жилд хэрэгжүүлэхээр Боловсролын сайдын 2024 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн А/123 дугаар тушаалаар шийдвэрлэсэн. Тус тушаалыг хэрэгжүүлэх хүрээнд Боловсролын ерөнхий газар нь "Юнайтед карьер" хөгжлийн төв НҮТББ-тай тэй хамтран “Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, хичээл сонголтод бэлтгэх үйл ажиллагаа”-ны удирдамжийг боловсруулан, календарьчилсан төлөвлөгөө гаргаж, ерөнхий боловсролын 20 сургуулийн 9-12 дугаар ангийн нийт 6000 гаруй суралцагчийг хамруулан тус үйл ажиллагааг зохион байгуулсан. Энэхүү үйл ажиллагааны хүрээнд хүүхдийнхээ авьяас, сонирхлыг таньж мэдэх, мэргэжил сонголтод нь туслахад сургах зорилгоор 3000 орчим эцэг эх асран хамгаалагчдад “Шинэ үеийн суралцагчдын сэтгэл зүйн онцлог ба мэргэжил сонголт” сэдвээр 13 удаагийн сургалт, төсөлд хамрагдсан 6000 суралцагчид шинжлэх ухааны аргачлал ашиглан өөрийгөө таньж мэдэх, ирээдүйн ажил мэргэжлээ зөв сонгоход нь туслах зорилготой “Миний мэргэжил, миний сонголт” сэдэвт 31 удаагийн сургалт, анги | 100% | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | удирдсан багш нарт Мэргэжил сонголтын чиг хандлага, сонирхлын үнэлгээний үр дүнд суурилан зөвлөгөө өгөх чиглэлээр 3 удаагийн сургалт зохион байгуулсан байна. Энэхүү үйл ажиллагааын үр дүнгийн тайланд дурдсанаар цаашид энэхүү төслийг улс орон даяар тогтмол хэрэгжүүлэх замаар мэргэжил сонголтын бодлогыг шинэ шатанд гаргах боломжтой бөгөөд 8-9 дүгээр ангид "Авьяас сонирхлоо зөв таньж, суралцах төлөвлөгөө боловсруулах, 10-12 р ангид "Сонгосон хичээлээ бие даан гүнзгийрүүлэн судлах, мэргэжлээ сонгох, мэргэжлийн суурь ур чадвараа хөгжүүлэхэд чиглсэсэн хөтөлбөрүүдийг боловсруулан үндэсний хэмжээнд хэрэгжүүлэх нь чухал байна.<br>Хавсралт: 2 файл | | |
| 1.1.23 | Сургалтын байгууллагын удирдах ажилтныг хуульд заасан шаардлагад нийцүүлэн бэлтгэх, давтан сургаж, мэргэжлийг дээшлүүлнэ. | 4,500.0 | Хуульд заасан шаардлагад нийцсэн сургалтад хамрагдсан багш, удирдах ажилтны тоо | 2,754 | - | 3000 | Боловсролын сайдын 2025 оны А/25 дугаар тушаалаар баталсан "Хүүхдийн цэцэрлэг, ЕБС-ийн багш, удирдах ажилтны мэргэжил дээшлүүлэх журам--ын дагуу 2024-2025 оны хичээлийн жилд Ерөнхий боловсролын сургуульд захирал, сургалтын менежерийн албан тушаалд 2,4,7 дахь жилдээ ажиллаж байгаа нийт 307 хүн хамрагдахаас 269 нь буюу 87.6 хувь нь хамрагдсан. | 50% | 50% |
| 1.1.25 | PISA - 2025 олон улсын сурлагын амжилт | - | PISA-2025 үнэлгээний үндсэн судалгаанд | - | 50 | 100 | Боловсролын ерөнхий хуулийн 35 дугаар зүйлийн 35.6-д “Боловсролын чанарыг гурван жил тутам олон улсын эрх бүхий байгууллагаар үнэлүүлнэ” хэмээн заасны дагуу Монгол Улс хоёр дахь удаагийн “PISA” үнэлгээнд 2025 онд хоёр дах удаагаа хамрагдах бэлтгэлийг хангах хүрээнд Боловсролын яам, харьяа байгууллагууд хамтран ажиллалаа. үүнд: 1. PISA 2025 туршилтын судалгааг 2025 оны 3 дугаар сард зохион байгуулж, нийт 32 сургуулийн 2513 сурагч | 90% | 90% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | ын судалгааг зохион байгуулах бэлтгэлийг хангаж, судалгааны ажлыг удирдлага, зохицуулалтаар хангана. | | хамрагдсан суралцагчийн хувь (192 сургуулийн 7450 суралцагч) | | | | даалгавар гүйцэтгэж, асуулга бөглөн, мөн тооны эцэг эх, 154 багш, 32 сургуулийн захирал, сургалтын менежер асуулга судалгаанд хамрагдсан. 2. PISA 2025 үндсэн судалгааг 2025 оны 03 дугаар сарын 13 ны өдрөөс 05 дугаар сарын 16 ны өдрийн хооронд Боловсролын яам, Боловсролын ерөнхий газар, Боловсролын үнэлгээний төв болон Боловсрол, сургалтын байгууллагууд хамтран зохион байгуулж, 191 сургуулийн түүвэрт сонгогдсон 7450 орчим суралцагч, тэдний эцэг эх, асран хамгаалагч, түүвэрт сонгогдсон сургуулийн багш, удирдах ажилтнууд хамрагдлаа. Тус судалгааны үр дүнгийн тайлан 2026 онд нэгтгэгдэн гарна. | | |
| 1.1.26 | Суралцагчийн дүрэмт хувцасны стандартыг шинэчлэх чиглэлээр судалгаа хийж, санал боловсруулах | - | Стандартыг шинэчлэн саналын боловсруулалтын хувь | - | 50 | 100 | Боловсролын сайд, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын хамтарсан тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг MNS6814:2019 “Сурагчийн дүрэмт хувцас. Техникийн шаардлага” стандартад өөрчлөлт оруулах эсэх, ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийн дүрэмт хувцасны нэр төрөлд поло загварын ханцуйтай цамц оруулах, суралцагчийн дүрэмт хувцасны чанар, эдэлгээ, загвар, хийц, нэр төрөл, хэрэглэгчийн сэтгэл ханамжийн талаар судалгаа хийхээр судалгааны төслийг боловсруулсан. Судалгааг хийхэд шаардагдах 26.2 сая төгрөгийн санхүүжилт шийдвэрлэгдээгүй. Судалгааг хот, аймгийн төв, сумдын сургуулиудаас сонгон хоёр сарын хугацаанд хийхээр төлөвлөсөн. Ажлын хэсэг хоёр удаа хуралдаж дүрэмт хувцасны талаар хийсэн бусад судалгаа, олон улсын туршлагаас хуваалцсан.<br>Хавсралт: 1 файл | 70% | 70% |
| 1.1.27 | “Сургуулийн соёл, суралцагчийн | - | Удирдамжийн төсөл боловсруулалт | - | 50 | 100 | ”Сургуулийн соёл-суралцагчийн төлөвшлийг дэмжих үйл ажиллагааны удирдамж”-ийг Боловсролын сайдын 2025 оны А/224 дүгээр тушаалаар батлууллаа. Энэхүү удирдамж нь сургуулийн эерэг соёл төлөвшүүлэхэд чиглэсэн бөгөөд энэ хүрээнд талуудын хамтын оролцоо, зөв хандлага, ёс зүй, харилцан хүндлэл, итгэлцэл, дэмжлэгт | 100% | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | төлөвшил” арга хэмжээг хэрэгжүүлэх удирдамжийн төсөл боловсруулах | | Хэрэгжилтийн хувь | | | | суурилан сургуулийн хамт олны үнэт зүйл, эерэг дадал, харилцаа, хандлагыг дэмжих, суралцагчийн төлөвшилд талуудын оролцоог нэмэгдүүлэх 4 чиглэлд хамаарах үйл ажиллагааг тус тус тодорхойлсон. Удирдамжийг төрийн болон орон нутгийн өмчийн ерөнхий боловсролын сургуулиуд өөрийн онцлогт нийцүүлэн 2025-2026 оны хичээлийн жилээс 3 үе шаттай хэрэгжүүлнэ. Мөн удирдамжид заасан үйл ажиллагааны хүрээнд хэрэгжүүлэх тогтмол ажлын төлөвлөгөөний нэгэн хувилбарыг боловсруулсан болно.<br>Хавсралт: 1 файл | | |
| 1.1.28 | “Эрүүл аюулгүй сургууль” арга хэмжээ, төлөвлөгөөг Эрүүл мэнд, Боловсролын сайд хамтран баталж, хэрэгжүүлнэ. | - | Арга хэмжээний төлөвлөгөөнийи төсөл боловсруулалт Хэрэгжилтийн хувь | 50 0 | 50 10 | 100 20 | Боловсролын сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2025 оны А/53, А/37 дугаар хамтарсан тушаалаар “Эрүүл, аюулгүй сургууль арга хэмжээ (2024-2028)-ний төлөвлөгөөг батлуулсан. Эрүүл, аюулгүй сургууль арга хэмжээний төлөвлөгөөг (1) эрүүл, аюулгүй сургуулийн эрх зүйн орчныг боловсронгуй болгох; (2) суралцагч, багш, ажилтны эрүүл мэндийн боловсрол, мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх; (3) сургуульд суурилсан эрүүл мэндийн хяналт, тандалтын цахим мэдээллийн сан бүрдүүлэх; (4) сургуульд эрүүл, аюулгүй, ээлтэй очин бүрдүүлэх; (5) сургуулийн эрүүл мэндийн үйлчилгээг бэхжүүлэх; (6) оролцогч талуудын тэгш оролцоо, түншлэл, үр дүнтэй хамтын ажиллагааг эхлүүлэх зорилтын хүрээнд 35 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Төлөвлөгөөг боловсрол, эрүүл мэндийн салбар болон орон нутгийн Засаг даргын тамгын газар хамтран хэрэгжүүлэх бөгөөд арга хэмжээний үр нөлөөг 17 шалгуур үзүүлэлтээр жил бүр дүгнэж байхаар тусгасан.<br>Хавсралт: 1 файл | 100% | 100% |
| 1.1.29 | ЕБС-ийн хэвлэмэл сурах бичигт тавих шаардлагын төслийг шинэчлэн боловср | - | MNS 5418:2008 Бага, дунд боловсролын хэвлэмэл сурах бичигт тавих шаардла | MNS 5418:2008 Бага, дунд боловсролын хэвлэмэл сурах | Холбогдох судалгааг хийнэ. 30% | Шаардлагын төслийг боловсруулсан байна. 100% | Боловсролын сайдын 2024 оны А/214 дүгээр тушаалаар "Ерөнхий боловсролын хэвлэмэл сурах бичигт тавих шаардлага" стандартыг төслийг холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтран шинэчлэн боловсруулж танилцуулахыг Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнд үүрэг болгосон. Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн ажлын хэсэг байгуулан стандартын төслийг шинэчлэн боловсруулж эхний шатны хэлэлцүүлгийг зохион байгуулсан. 2025 оны 5 дугаар сард стандартын төслийн хэлэлцүүлэгт оролцон саналаа хүргүүлсэн. Мөн тус стандартын төсөлд тусгах саналыг боловсруулан 2025 оны 1 дүгээр сард Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнд хүргүүлсэн /саналыг хавсаргав/. Ажлын хэсгийн ахлагчтай холбогдож | 100% | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | уулна. | | гын төсөл боловсруулалтын хувь | бичигт тавих шаардлага | | | шаардлагатай бичиг баримт, саналаа хүргүүлэн хамтран ажиллаж байна. Хавсралт: 1 файл | | |
| 1.1.30 | Боловсролын яамны дэргэдэх “Хүүхдийн төлөө дэд зөвлөлийн ажиллах дүрэм”-ийг боловсруулж, батлуулах | - | Дүрмийн төсөл боловсруулалтын хувь, баталсан шийдвэр | - | 100% | - | Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн 2023 оны 01 дүгээр тогтоолоор батлагдсан “Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн дүрэм”-ийн 3.6-д заасны дагуу Боловсролын яамны дэргэд боловсролын салбарын хүүхдийн эрхийг хангах, холбогдох хууль тогтоомж, хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, хэрэгжилтийг хангах дэд зөвлөлийг байгуулсан. Энэхүү Боловсролын яамны дэргэдэх “Хүүхдийн төлөө дэд зөвлөлийн ажиллах дүрэм”-ийг боловсруулан Боловсролын сайдын 2025 оны А/24 дүгээр тушаалаар батлууллаа. Дэд зөвлөлийн дүрэмд зөвлөлийн ажиллах зарчим, чиг үүргийг тодорхойлж, зөвлөлийн үйл ажиллагааны зохион байгуулалт, тайлагнал, хяналтыг нарийвчлан зохицууллаа. Боловсролын яамны дэргэдэх хүүхдийн төлөө дэд зөвлөлийн 2025 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг дэд зөвлөлийн дарга бөгөөд Төрийн нарийн бичгийн даргаар батлуулан, хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. Хавсралт: 1 файл | 100% | 100% |
| 1.1.31 | "Сайн багшийг таны дэргэд" цогц арга хэмжээг хэрэгжүүлнэ. | 1000.0 | Арга хэмжээний хэрэгжилтийн хувь | - | 5 | 20 | Сайн багшийг таны дэргэд арга хэмжээг боловсруулахын тулд багшийн хүрэлцээ хангамж, ажлын байрны нөхцөл, орчин, сэтгэл ханамж, сайн багшийн дүр төрх, шалгуур үзүүлэлт зэргийг судлан, арга хэмжээг хэрэгжүүлэх хэрэгцээ, шаардлагыг судлах, бодлогын зөвлөмж, арга хэмжээний төсөл боловсруулах зөвлөн үйлчилгээг авахаар Боловсролын сайдын тушаалын төслийг боловсруулан хянуулж байна. Тус зөвлөх үйлчилгээний үр дүнд арга хэмжээг 2025 оны 10 дугаар сард багтаан батлуулахаар төлөвлөсөн. | 30% | 30% |
| 1.1.32 | "Багшийн 3 тулгуурт бодлого" цогц арга хэмжээг | 71,081.000 | Арга хэмжээний төлөвлөгөө боловсруулалты | 0, 77,- | 5, 77,- | 50, 78, 15 | Засгийн газрын 2024 оны 192 дугаар тогтоолын хавсралтаар баталсан БАГШИЙН ГУРВАН ТУЛГУУРТ БОДЛОГО" цогц арга хэмжээг хэрэгжүүлэх хүрээнд дараах үйл ажиллагааг зохион байгуулж ажиллалаа. Үүнд: 1. Арга хэмжээний 3.1.1.шинэ багшийг ажлын байрны чиг үүрэгт дадлагажуулах, сургалтын орчин нөхцөлд дасан зохицоход дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд Боловсролын сайдын 2025 оны "Журам батлах тухай" А/25 дугаар тушаалаар | 70% | 70% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | хэрэгжүү лнэ. | | н хувь Ерөнхий боловсролын сургуулийн багшийн гүйцэтгэлийн үнэлгээний улсын дундаж Багшийн мэргэжлийн чадамжийн стандартын хэрэгжилтийн хувь | | | | "Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багш, ажилтны мэргэжлийн хөгжлийн үйл ажиллагааны журам"ын 2.2-т "Багшийг дадлагажуулах үйл ажиллагаа"-г нэг хичээлийн жилийн турш хэрэгжүүлэх ,2.2.3-т "цэцэрлэг, сургуульд анхны жилдээ ажиллаж байгаа багш болон Боловсролын ерөнхий хуулийн 12.16-д заасан дагалдан багш, 2.2.4-т багшийн чадамжийн стандартад хүрсэн түвшин, ажлын гүйцэтгэл, үр дүнг харгалзан 2, 3 дахь жилдээ ажиллаж байгаа болон сүүлийн 5-аас доошгүй жил багшаар ажиллаагүй багшийг тус тус энэхүү үйл ажиллагаанд хамруулахаар зааж, хэрэгжүүлэн ажиллаж байна. 2. Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны А/430 дугаар тушаалаар баталсан ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН БАГШИЙН АЖЛЫГ ҮНЭЛЭХ, ДҮГНЭХ ЖУРАМ-ын дагуу багшийн ажлын чанар, сургалтын үр дүнг үнэлж, багшийн мэргэжлийн хөгжлийн хэрэгцээг тодорхойлох, өөрийн үйл ажиллагааны гүйцэтгэлээ удирдах, хариуцлагатай хандах соёлыг төлөвшүүлэх,сургалтын чанарыг сайжруулах зорилгоор 2025 оны багшийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээг улсын хэмжээнд 05 дугаар сарын 12-ноос 23-ны өдрүүдэд зохион байгуулсан. Үнэлгээний үр дүн 2025 оны 08 дугаар сард гарна. 3. Арга хэмжээний 3.1.7.Багшийн нэр хүнд, үнэлэмжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн олон нийтэд нөлөөллийн ажлуудыг тогтмол зохион байгуулах хүрээнд Боловсролын сайдын 2025 оны А/30 дугаар тушаалаар бүх шатны боловсролын байгууллагад 2025 оныг "Байгууллагын соёл, багшийн ёс зүйн жил" болгон зарласан бөгөөд сургалтын байгууллагын менежмент, соёл төлөвшлийг дэмжих үйл ажиллагаанд 120 сургуулийг хамруулсан /БС-ын 2024 оны А/72, А/136 тушаал/.<br>Хавсралт: 1 файл | | |
| 1.1.33 | Мэргэжлийн багшийн хүрэлцээ, хангалтыг нэмэгдүүлэх арга замыг судалж, | 18,247.80 | Мэргэжлийн багшаар бүрэн хангагдсан сургуулийн эзлэх хувь | 21.9 | 21.9 | 28 | Ерөнхий боловсролын 885 сургуулийн 534 сургууль буюу 60.3 хувь нь мэргэжлийн багшаар бүрэн хангагдсан. Нийт багш нарын 86.7 хувь нь (32.7 мянга) нь төрийн, 13.3 хувь (5.0 мянга) нь хувийн өмчийн сургуульд ажиллаж байна. Багшийн тоо өмнөх хичээлийн жилээс 2.1 хувь буюу 777-оор нэмэгдсэн байна. | 30 % | 30 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | хомдслыг үе шаттайгаар бууруулна. | | | | | | | | |
| 1.1.34 | Багш, ажилчдын цалин, хөдөлмөрийн хөлсний хэмжээг мөнгө, төсвийн бодлого, Үйлдвэрчний эвлэлийн холбоотой байгуулсан хамтын хэлэлцээртэй уялдуулан, үе шаттайгаар нэмэгдүүлэх санал боловсруулж, холбогдох нэгж, | 166,233.40 | Багш, ажилтны дундаж цалин хөлс | 2,464.9 (Багшийн дундаж цалин хөлс) | 2,464.9 | 2,612.80 | Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн "Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 238 дугаар тогтоолын 47 дугаар хавсралтаар Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллагын төрийн үйлчилгээний албан тушаалын цалингийн доод хэмжээг шинэчлэн баталснаар ЕБС-ийн багшийн үндсэн цалин 2024 онтой харьцуулахад 6 хувиар нэмэгдэж, 1,484,000 төгрөг болсон. | 70% | 70% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | байгууллагуудтай хамтран ажиллана. | | | | | | | | |
| 1.1.35 | Багшийн орон сууцны нөхцлийг сайжруулах арга хэмжээг холбогдох яамтай хамтран хэрэгжүүлнэ. | 1,500.0 | Орон сууцны нөхцөлөө сайжруулсан багшийн тоо | - | - | 50 | --- | 0% | 0% |
| 1.1.36 | Бага ангийн 2,000 багш, ерөнхий боловсролын сургуулийн 11,000 багш (тусгай хэрэгцээт боловсролын багшийг | 285.0 | Бага ангийн багшаар бэлтгэгдэж, мэргэшсэн багшийн тоо, Ерөнхий боловсролын багш (тусгай хэрэгцээт боловср | - | - | 1,000, 400, 500 | Боловсролын сайдын 2025 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн “Журам батлах тухай” А/25 дугаар тушаалын хоёрдугаар хавсралтаар батлагдсан “Хүүхдийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багш, удирдах ажилтны мэргэжил дээшлүүлэх журам”-ын хүрээнд мэргэжил дээшлүүлэх үндсэн сургалтад хүүхдийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуульд 5,10,15,20 дахь жилдээ ажиллаж буй багш, 2,7,12 дахь жилдээ ажиллаж буй удирдах ажилтнууд нийт 5536 хүн танхимын сургалтад хамрагдсан байна. Bagsh.edu.mn цахим платформд 5872 багш удирдах ажилтан бүртгэл үүсгэн сургалтад хамрагдсанаас амжилттай суралцаж төгссөн буюу 70 ба түүнээс дээш оноо авч батламж авсан 4632 хүн байна. | 70% | 70% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | оруулаад), англи хэлний 2,000 багшийг мэргэжил дээшлүүлэх сургалтад хамруулж, мэргэшүүлнэ. | | олын багш орно)-аар бэлтгэгдэж, мэргэшсэн багшийн тоо , Англи хэлний багшаар бэлтгэгдэж, мэргэшсэн багшийн тоо | | | | | | |
| 1.1.38 | Ерөнхий боловсролын сурах бичгийг цахимжуулна. | 8,500.00 | Ерөнхий боловсролын сургуулийн цахим сурах бичгийг тоо | 33 | 33 | 96 | Ерөнхий боловсролын сургуулийн бага ангийн хэвлэмэл сурах бичгийг дижитал хэлбэрт хөрвүүлэх, сургалтад цахим сурах бичгийн систем турших ажлын хүрээнд 13,500 орчим интерактив дасгал, даалгаврын сантай, сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт, суралцахуйн явц, үр дүнтэй холбоотой мэдээллийг цахим технологи ашиглан богино хугацаанд цуглуулах, багшийн ажлын ачааллыг бууруулах, арга зүйгээ төлөвлөхөд дэмжлэг үзүүлэх цогц цахим систем, боловсролын мэргэжлийн байгууллагын холбогдох хүний нөөц, ерөнхий боловсролын сургуулийн багш нар цахим арга хэрэгсэл, модуль ашиглан интерактив дасгал, даалгавар боловсруулах программ бүхий бага ангийн 1-5 дугаар ангийн 33 сурах бичгийн агуулга, дасгал, даалгаврыг интерактив хэлбэрт хөрвүүлж Боловсролын ерөнхий газар хүлээн авсан. Тус цахим систем нь хичээлийн хуваарь, сурагчдын ирц, интерактив сурах бичгийн дасгал, даалгаврын гүйцэтгэл, цахим сурах бичгийн ашиглалттай холбоотой их өгөгдлийг сурагч, анги, бүлэг, сургууль, дүүрэг, аймаг, үндэсний түвшинд үүсгэх, дүн шинжилгээ хийх, хянах, сурах бичгийг интерактив хэлбэрт хөрвүүлэх, дасгал даалгаврыг хөгжүүлэх, шинээр зохиох тусгайлсан багаж, хэрэгсэлтэй тул сурах бичиг зохиогч, хөгжүүлэгч нар өөрсдөө интерактив сурах | 100% | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | бичиг зохиох боломжтой. Боловсролын ерөнхий газраас 2025 оны 05 дугаар сард аймаг, нийслэлийн боловсролын газрын бага боловсрол хариуцсан мэргэжилтнүүдэд цахим сурах бичгийг ашиглах арга зүйн сургалтыг зохион байгуулсан. Цахим сурах бичгийг https://e-sur.edu.mn/ цахим хуудсанд нээлттэй байршуулсан бөгөөд бага ангийн суралцагчид, багш нар байнга ашиглаж байна.<br>Хавсралт: 3 файл | | |
| Гурав. Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ | | | | | | | | | |
| 3.1. | Ерөнхий боловсролын салбарын нийтлэг харилцааг зохицуулах эрх зүйн баримт бичиг боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг бодлогын удирдлага, зохицуулалтаар хангах | - | Эрх зүйн актуудыг боловсруулж, хэрэгжилтэд дэмжлэг үзүүлсэн байна. | - | Эрх зүйн актуудыг боловсруулж, хэрэгжилтэд дэмжлэг үзүүлсэн байна. | | 1. “Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багш, ажилтны мэргэжлийн хөгжлийн үйл ажиллагааны журам”, “Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багш, удирдах ажилтны мэргэжил дээшлүүлэх журам”-ыг тус тус Боловсролын сайдын 2025 оны А/25 дугаар тушаалаар 2 "Сурах бичгийн эхийг зохиох, санал авах, дүгнэлт гаргуулах үйл ажиллагааны журам-ыг Боловсролын сайдын 2025 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн А/87 дугаар тушаалаар Боловсролын сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2025 оны А/53, А/37 дугаар хамтарсан тушаалаар “Эрүүл, аюулгүй сургууль арга хэмжээ (2024-2028)-ний төлөвлөгөөг тус тус батлуулж, - Ерөнхий боловсролын сургууль, дотуур байрны орчинд хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх журмын төсөл - Суурь, бүрэн дунд боловсрол эзэмшигчид боловсролын баримт бичиг олгох журам, боловсролын баримт бичгийн загварыг шинэчлэх төсөл -Бага боловсролын түвшинд гэрийн сургалт зохион байгуулах, түүнд хяналт тавих журмын төслийн тус тус боловсруулсан. | 90 % | 90 % |
| 3.1. | Ерөнхий боловср | - | Төсөл боловср | - | 30 | 100 | Төрийн болон орон нутгийн өмчийн ерөнхий боловсролын сургуулийн багшаас бусад, захиргааны удирдлага, ажилтны орон тооны хязгаарын | 70 % | 70 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | олын сургуулийн багш, ажилтны ажлын норм, нормативын төсөл боловсруулна. | | уулалтын хувь | | | | жишиг нормативыг хэрэгжүүлэх заавар”-ыг Сангийн сайдтай хамтран батлахаар 2025 оны 04 дүгээр сард санал хүргүүлсэн бөгөөд 2025 оны 05 дугаар сард тус яамнаас хариу ирүүлсэн тул саналыг тусган дахин хүргүүлээд байна. Орон тооны хязгаарын жишиг нормативт дараах асуудлуудыг тусгасан. Үүнд: 1. Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуульд заасан сэтгэл зүйч, хоол зүйч, эмч, Багшийн хөгжлийг дэмжих тухай хуульд заасан багшийн туслах, багш хөгжлийн төвийн менежер ерөнхий боловсролын сургууль тус бүрд ажиллах болон, Боловсролын сайдын 2025 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн А188 дугаар тушаалаар “Төрөлжсөн ахлах сургуулийн талаар баримтлах чиглэл”-д нийцүүлэн “Карьер хөгжлийн төвийн менежер”, мөн сонгон судлах хөтөлбөрөөс ирээдүйд эзэмших ажил мэргэжлийн дагуу сонголт хийх, үнэлгээнд хамрагдахад дэмжлэг үзүүлэх “төрөлжсөн хөтөлбөрийн сургалтын менежер” орон тоог нэмж, энэ нь зөвхөн Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 20.6-д заасан төрөлжсөн ахлах сургуульд хамаарахыг зааварт оруулсан. 2. Одоогоор Монгол улсын хэмжээнд нийт 56 бага сургууль сургалтын үйл ажиллагаа эрхэлж байгаагаас 28 нь 50-аас доош тооны суралцагчтай, 28 нь 50-100 суралцагчтай байгаа онцлогийг харгалзан 50 хүртэл тооны суралцагчтай бага сургуулийн орон тооны жишиг хязгаарыг тусгайлан зохицуулсан. 3. Ерөнхий боловсролын сургуулийн багшийн ажлын ачаалал, норм нормативыг шинэчлэн тогтооход шаардагдах судалгааг БСҮХ-ийн боловсролын эдийн засгийн судалгааны сектор, зөвлөх үйлчилгээний тусламжтайгаар хийж гүйцэтгэхээр ажиллаж байна.<br>Хавсралт: 1 файл | | % |
| 3.1.2 | "Боловсролын салбар дахь хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх журам"- | - | Журмын төсөл боловсруулалтын хувь | 0 | 100 | - | Ерөнхий боловсролын сургууль, дотуур байрны орчинд хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх журмын төслийг маягтуудын хамт эцэслэн боловсруулж, нийслэлийн ерөнхий боловсролын сургуулийн нийгмийн ажилтны төлөөлөл (2025.04.23) болон Боловсролын ерөнхий газар, Сургуулийн нийгмийн ажилтны нийгэмлэг, нийслэлийн боловсролын газрын мэргэжилтнүүд (2025.05.09), олон улсын байгууллагын төлөөлөл (2025.05.12)-өөр тус тус 3 удаа хэлэлцүүлж, санал аваад байна. Хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх журмын төсөл нь хүүхэд хамгааллын үйлчилгээ, хэрэгжүүлэх үйл ажиллагаа, үйлчилгээний бүтэц, зохион байгуулалт, хяналт, үнэлгээ гэсэн агуулгыг хамарсан. Хүүхэд хамгааллын үйлчилгээнд шуурхай тусламжийн, | 100% | 90% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | ын төслийг боловсруулж, батлуулна. | | | | | | хамгаалах нөхөн сэргээх, урьдчилан сэргийлэх үйлчилгээг хамруулахаар тусгасан бөгөөд үйлчилгээ тус бүрт хэрэгжүүлэх үйл ажиллагаа, түүнийг хариуцах гүйцэтгэх албан хаагчийг нарийвчлан зохицуулсан. Хүүхэд хамгааллын тухай хуулийн 25.5.1-д “Боловсролын орчин дахь хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх журам” гэж заасан тул сургуулийн өмнөх болон мэргэжлийн болон техникийн боловсролын байгууллагын асуудал хариуцсан нэгжээс журмын хавсралтаа ирүүлэхээр батлуулахаар ажиллаж байна.<br>Хавсралт: 1 файл | | |
| 3.1.3 | Хүүхдийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багш, ажилтны мэргэжлийн хөгжлийн үйл ажиллагааны журам, мэргэжил дээшлүүлэх журмыг боловсруулан батлуулна. | - | Журмын төсөл боловсруулалтын хувь | - | 100 | 100 | “Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багш, ажилтны мэргэжлийн хөгжлийн үйл ажиллагааны журам”, “Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багш, удирдах ажилтны мэргэжил дээшлүүлэх журам”-ыг тус тус Боловсролын сайдын 2025 оны А/25 дугаар тушаалаар батлууллаа. Энэхүү журмаар багшийг ажилласан жилээс үл хамаарч тэдний чадамжид суурилан ажил үүргээ гүйцэтгэхэд нь шууд хэрэглээ болох агуулгад чиглүүлэн ажлын байранд нь болон орон нутагт хөгжлийг дэмжих сургалт, үйл ажиллагааг чанар, үр дүнтэй зохион байгуулах, мөн анхны жилдээ ажиллаж байгаа багшийг багшлах ажилд дагалдуулан сургах, зөвлөн туслах үйл ажиллагаанд хамруулахаар зохицуулсан. Харин мэргэжил дээшлүүлэх сургалт нь үндсэн болон төрөлжсөн гэсэн 2 төрөлтэй, үндэсний болон орон нутгийн түвшинд зохион байгуулах, багш 5 жил тутамд багшийн чадамжийн стандартын түвшин ахиулах үндсэн сургалтад нийт 4 хүртэлх удаа, удирдах ажилтан чадамжийн түвшин ахиулах үндсэн сургалтад тухайн албан тушаалд томилогдон ажилласан 2 дахь жилээс эхлэн 5 жил тутамд нийт 3 хүртэлх удаа тус тус хамрагдахаар зохицуулсан. Сургалт шатлан гүнзгийрсэн агуулгатай байх бөгөөд төрөлжсөн сургалтыг үндэсний түвшинд боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага багшийн хөгжлийг дэмжих үндэсний төвтэй, орон нутгийн түвшинд аймаг, нийслэлийн боловсролын газар багшийн хөгжлийг дэмжих бүсийн төвтэй хамтран зохион байгуулна. Нэр бүхий 2 журмыг танилцуулах сургалтыг Боловсролын ерөнхий газар, аймаг, нийслэлийн боловсролын газрын дарга, мэргэжилтэн болон Дундговь, Өмнөговь аймгийн цэцэрлэг, сургуулийн захирал, эрхлэгч, сургалтын менежер, арга зүйч нарт тус тус зохион байгууллаа. | 100% | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Хавсралт: 1 файл | | |
| 3.1.4 | Сургуулийн нийгмийн ажилтанд мэргэшлийн зэрэг олгоход тавигдах шалгуур үзүүлэлтийн төсөл боловсруулна. | - | Шалгуур үзүүлэлтийн төсөл боловсруулалтын хувь | - | 30 | 100 | Сургуулийн нийгмийн ажилтанд мэргэшлийн зэрэг олгоход тавигдах шалгуур үзүүлэлтийн төслийг боловсруулж, Сургуулийн нийгмийн ажилтны нийгэмлэг, нийслэлийн ерөнхий боловсролын сургуулийн нийгмийн ажилтны төлөөлөл (2025.03.14) болон нийгмийн ажилтан бэлтгэдэг их, дээд сургуулийн мэргэжлийн тэнхимийн багш нар (2025.04.28, 2025.05.27)-аар тус тус 3 удаа хэлэлцүүлж, санал аваад байна. Шалгуур үзүүлэлтийн төсөл нь хүүхэд хамгааллын ажил, хүүхэд хамгааллын хөтөлбөр, үйлчилгээний загвар, судалгаа, шинжилгээ, арга зүйн зөвлөгөө, дэмжлэг, хамтын ажиллагаа, олон нийтийн оролцоо, мэргэжлийн хөгжил гэсэн агуулгыг хамарсан. Мэргэшлийн ахлах, тэргүүлэх, зөвлөх зэрэг тус бүрд 10 шалгуур үзүүлэлт байхаар тусгасан. Шалгуур үзүүлэлт бүр нь тодорхой, хэмжихүйц байдлыг хангаж, нотлох баримтаар баталгаажих боломжтой байх, шатлал ахих тусам шаардлагатай мэдлэг, ур чадвар, арга зүйн манлайлал гүнзгийрч байгаа шаталсан бүтэцтэй байхаар томьёолсон. Харин Засгийн газрын 2013 оны 229 дүгээр тогтоолоор баталсан “Сургуулийн нийгмийн ажилтанд мэргэшлийн зэрэг, нэмэгдэл хөлс олгох журам”-ыг холбогдох хуульд нийцүүлэн хүчингүй болгох тухай Засгийн газрын тогтоолын төслийг танилцуулгын хамт бэлтгээд байна.<br>Хавсралт: 2 файл | 90 % | 90 % |
| 3.1.5 | Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангид багш мэргэжлийн сонгон бүлэг хичээллүүлэх журам, сургалт | - | Журмын төсөл боловсруулалтын хувь | - | 50 | 100 | Боловсролын сайдын 2025 оны А/188 дугаар тушаалаар “Төрөлжсөн ахлах сургуулийн талаар баримтлах чиглэл”-ийг батлуулсан бөгөөд төрөлжсөн ахлах сургууль нь 10-12 дугаар ангитай байх бөгөөд суралцагчдад бүрэн дунд боловсрол эзэмшүүлэхийн зэрэгцээ тэднийг дараагийн түвшний боловсрол болон ажил мэргэжлээ сонгоход бэлтгэх, мэргэжлийн эрх олгох/мэргэжлийн сургалт, үйл ажиллагаа зохион байгуулах чиг үүргийг хэрэгжүүлэх, их сургууль, коллежитой хамтарсан хөтөлбөр хэрэгжүүлэх, эсхүл их сургууль, коллеж, мэргэжлийн боловсролын сургуулийн мэргэжлийн суурь хичээлийг сонгон судлах хичээлээр суралцагч судалж болох эрхийг нээж өгсөн. Энэхүү чиглэлийн 2.5-д Төрөлжсөн ахлах сургууль нь "Боловсролын ерөнхий хуулийн 12.2 т заасан багш мэргэжлийн сонгон бүлгийг холбогдох журмын дагуу зохион байгуулж болно" гэж заасан. Тус чиглэлтэй уялдуулан "Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангид багш мэргэжлийн сонгон бүлэг хичээллүүлэх журам, сургалтын | 30 % | 30 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | ын хөтөлбөрт тавих шаардлагыг боловсруулж батална. | | | | | | хөтөлбөрт тавих шаардлага"-ыг 2025 оны 2 дугаар хагас жилд боловсруулан батлуулна. | | |
| 3.1.6 | Суурь, бүрэн дунд боловсрол эзэмшигчид боловсролын баримт бичиг олгох журам, боловсролын баримт бичгийн загварыг шинэчлэн батална. | - | Журмын төсөл боловсруулалтын хувь, батлагсан шийдвэр | - | 50 | 100 | Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны "Журам батлах тухай" А/156 дугаар тушаалаар баталсан "Суурь, бүрэн дунд боловсрол эзэмшигчдэд боловсролын баримт бичиг олгох, дүйцүүлэх журам" хүчин төгөлдөр үйлчилж байна. Боловсролын ерөнхий хуульд: 9.2. Суурь, бүрэн дунд боловсрол эзэмшсэн төгсөгчид гэрчилгээ, мэргэжлийн боловсрол эзэмшсэн төгсөгчид гэрчилгээ, үнэмлэх, техникийн болон дээд боловсрол эзэмшсэн төгсөгчид диплом олгоно. 9.3.Боловсролын болон сургалтын баримт бичгийн загвар, түүнийг хөтлөх, олгох журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална. 9.5. Гадаад улсын боловсролын болон сургалтын баримт бичгийг Монгол Улсын боловсролын баримт бичигтэй дүйцүүлэх, багц цаг харилцан хүлээн зөвшөөрөх журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална гэж тус тус заасныг хэрэгжүүлэх зорилгоор хуулийн 9.3-т заасан "Суурь, бүрэн дунд боловсрол эзэмшигчдэд боловсролын баримт бичиг олгох журам"-ын төсөл, боловсролын баримт бичгийн загвар, мөн хуулийн 9.5-д заасан Гадаад улсын боловсролын болон сургалтын баримт бичгийг Монгол Улсын боловсролын баримт бичигтэй дүйцүүлэхэд хамаарах " суурь, бүрэн дунд боловсрол эзэмшсэн иргэний ижил түвшний боловсролын баримт бичгийг Монгол Улсын боловсролын баримт бичигтэй дүйцүүлэх журам"-ын төслийг тус тус боловсруулан сайдын тушаалын төслийг Яамны албан хэрэг хөтлөлтийн цахим системд оруулсан. Тус журмын төсөлд Захиргааны ерөнхий хуулийн 61.4-т заасан нөлөөллийн шинжилгээ, 62 дугаар зүйлд заасан санал авах үйл ажиллагааг 2025 оны 2 дугаар улиралд зохион байгуулж, оролцогч талуудаар хэлэлүүлэн, санал тусган сайжруулж батлуулахаар бэлтгэж байна. https://mongolianeducation.sharepoint.com/:w:/s/albanbichig/EemA-g15q5JJixtgpQaEm5QBkx0EichDI_kpqK6LJhDV6w?e=ZyfWL9 | 100% | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 3.1.7 | Бага боловсролын түвшинд гэрийн сургалт зохион байгуулах, түүнд хяналт тавих журмыг баталж хэрэгжилтэд дэмжлэг үзүүлнэ. | - | Журмын төсөл боловсруулалтын хувь, баталсан шийдвэр | - | 50 | 100 | Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай 22 дугаар зүйлийн 22.7-д "Эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн хүсэлтээр бага боловсролыг гэрийн сургалтаар эзэмшүүлж болох бөгөөд гэрийн сургалт зохион байгуулах, түүнд хяналт тавих журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална." гэснийг хэрэгжүүлэх зорилгоор ."Гэрийн сургалт зохион байгуулах, түүнд хяналт тавих журам"-ын төслийг боловсруулан сайдын тушаалын төслийг төлөвлөж, Яамны албан хэрэг хөтлөлтийн цахим системд оруулсан. Тус журмын төсөлд Захиргааны ерөнхий хуулийн 61.4-т заасан нөлөөллийн шинжилгээ, 62 дугаар зүйлд заасан санал авах үйл ажиллагааг 2025 оны 2 дугаар улиралд зохион байгуулж, оролцогч талуудаар хэлэлцүүлэн, санал тусган сайжруулж батлуулахаар бэлтгэж байна. https://mongolianeducation.sharepoint.com/:w:/s/albanbichig/ETFaOn_HJHhNg6f97OrWA1kB63I5o0YORWBG6oou2bUOmA?e=wZ36Ya<br>Хавсралт: 1 файл | 100% | 100% |
| 3.1.8 | Боловсролын салбар дахь хүүхэд хамгааллын үйлчилгээний нийтлэг шаардлагын төсөл боловсруулна. | - | Шаардлагын төсөл боловсруулалтын хувь | - | - | 100% | Хүүхэд хамгааллын тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд “Боловсролын орчин дахь хүүхэд хамгааллын үйлчилгээний нийтлэг шаардлага”-ын төслийг боловсруулж, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн ерөнхий газар, Боловсролын ерөнхий газар, нийслэлийн боловсролын газрын холбогдох нэгжийн дарга, мэргэжилтний төлөөлөл (2025.04.11), түүнчлэн нийслэлийн сургуулийн нийгмийн ажилтны төлөөлөл (2025.05.09)-өөр тус тус хэлэлцүүлж, санал авч, эцэслэсэн. Нийтлэг шаардлагын төсөлд боловсролын орчинд үзүүлэх хүүхэд хамгааллын үйлчилгээ, хүний нөөц, сургалтын байгууллагын орчин, санхүүжилт, хяналт-шинжилгээ, үнэлгээнд тавих шаардлагыг тус тус тогтоосон бөгөөд боловсролын орчинд хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэхдээ “Нийгмийн ажлын үйлчилгээний нийтлэг шаардлага MNS 6949:2021” стандартыг мөрдлөг болгож, өмчийн хэлбэрээс үл хамаарч уг шаардлагыг дагаж мөрдөхөөр заасан. Хүүхэд хамгааллын тухай хуулийн 23.9-д уг нийтлэг шаардлагыг хүүхэд, гэр бүлийн хөгжлийн болон боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батлахаар заасан тул Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам (2025.05.09-ний өдрийн 1/1974 тоот), хамтран батлахаар албан бичиг хүргүүлээд байна. Тус байгууллагуудаас батлан ирүүлэхийг хүлээж байна. | 100% | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Хавсралт: 2 файл | | |
| 3.1.9 | Боловсролын сургалтын байгууллага, сүм хийдийн орчны аюулгүй байдалд нөхцөл байдлын үнэлгээ хийх журам | - | Журмын төсөл боловсруулалтын хувь | - | 30 | 100 | Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны сайд, Боловсролын сайдын хамтарсан тушаалаар батлах “Боловсролын сургалтын байгууллага болон сүм хийдийн орчны аюулгүй байдалд нөхцөл байдлын үнэлгээ хийх журам”-ын төслийг холбогдох нэгж, яамны мэргэжилтнүүдтэй хамтран боловсруулсан. Журмын төслийн эхний хэлэлцүүлгийг холбогдох нэгж, яамны мэргэжилтнүүдийг оролцуулан хийсэн. Дараагийн хэлэлцүүлгүүдийг хийж журмын төслийг сайжруулан 2025 оны сүүлийн хагас жилд батлуулахаар төлөвлөн ажиллаж байна.<br>Хавсралт: 1 файл | 100% | 100% |
| 3.1.10 | Сурах бичгийн эхийг зохиох, санал авах, дүгнэлт гаргуулах үйл ажиллагааны журам боловсруулна. | - | Журмын төсөл боловсруулалтын хувь | - | 50 | 100 | Боловсролын сайдын 2025 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн А/87 дугаар тушаалаар "Сурах бичгийн эхийг зохиох, санал авах, дүгнэлт гаргуулах үйл ажиллагааны журам" батлагдсан. Тус журмыг Хууль зүй, дотоод хэргийн яам Захиргааны ерөнхий хуулийн дагуу хянаад захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн сангийн 7229 дугаарт бүртгэсэн. Тус журмыг Боловсролын ерөнхий газар, Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнд хүргүүлсэн бөгөөд журмын хэрэгжилтийг ханган ажиллаж байна.<br>Хавсралт: 1 файл | 100% | 100% |
| Гурав. Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ | | | | | | | | | |
| 4.1. | Ерөнхий боловсролын салбары | - | - | - | - | | Ерөнхий боловсролын газрын чиг үүрэгт хамаарах урт болон богино хугацааны бодлогын баримт бичиг, төсөл, хөтөлбөр, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг тухай бүрд тайлагнаж ажилласан. Үүнд: 1. Нэгжийн 14 хоног тутмын мэдээ, сар бүрийн тайлан 2. Ерөнхий | 100% | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | н урт болон богино хугацааны бодлогын баримт бичиг, төсөл, хөтөлбөр, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн болон үйл ажиллагааны төлөвлөлт, хэрэгжилт, тайлагналт, архив, албан хэрэг хөтлөлт, дотоод үйл ажиллагааны тасралтгүй байдлыг | | | | | сайдын албан даалгаварын хэрэгжилт 3. Хууль, тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн улирлар тутмын тайлан 4. Салбарын удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын биелэлт 5. Алсын хараа 2050, Улсын хөгжлийн жилтийн төлөвлөгөө, МУ-ыгн хөгжлийн 5 жилийн үндсэн чиглэл 6. Цаг үеийн шинжтэй үүрэг даалгавар, яамны бусад нэгжээс дотоод бичгээр ирүүлсэн холбогдох хууль, тогтоомж, шийдвэр, зөвлөмжийн хэрэгжилт, Засгийн газар болон бусад яамдаас шаардсан тайлан мэдээллийг тус тус нэгжийн хүрээнд нэгтгэн тайлагнаж, Боловсролын яамны 2024 оны хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу архивын баримт бичгийн бүрдлийг хангуулан архивт хүлээлгэн өгсөн. | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | хангах | | | | | | | | |
| 4.1.1 | Ерөнхий боловсролын салбарын мэдээллийн ил тод байдлыг ханган ажиллана. | - | Мэдээллийн ил тод байдал | 2024 оны гүйцэтгэлийн түвшингээр | Ерөнхий боловсролын салбарт хамаарах эрх зүйн акт, үйл ажиллагааны талаарх мэдээллийг хуульд заасны дагуу эрх ашиг хөндөгдөх талууд, олон нийтэд хүргэсэн байна. | Ерөнхий боловсролын салбарт хамаарах эрх зүйн акт, үйл ажиллагааны талаарх мэдээллийг хуульд заасны дагуу эрх ашиг хөндөгдөх талууд, олон нийтэд хүргэсэн байна. | Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор шинэчлэн боловсруулж байгаа, боловсруулсан захиргааны болон хэм хэмжээний актуудтай холбогдох мэдээ, мэдээллээр холбогдох талуудыг хангаж, санал авч, тусгаж ажиллалаа. Үүнд: 1. Боловсролын сайдын 2025 оны А/25, А/106, А/188 дугаар тушаалаар батлагдсан “Цэцэрлэг, ЕБС-ийн багш, ажилтны мэргэжлийн хөгжлийн үйл ажиллагааны журам”, “Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багш, удирдах ажилтны мэргэжил дээшлүүлэх журам”, “Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны багшийн албан тушаалд тавих нийтлэг шаардлага”, “Төрөлжсөн ахлах сургуулийн талаар баримтлах чиглэл” 2. Ерөнхий боловсролын сургууль, дотуур байрны орчинд хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх журам”, 3. “Боловсролын орчин дахь хүүхэд хамгааллын үйлчилгээний нийтлэг шаардлага”-ын төсөл /https://moe.gov.mn/post/165283 https://moe.gov.mn/post/154822 4. Боловсролын сайд, Эрүүл мэндийн сайдын 2025 оны А/53, А/37 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан "Эрүүл, аюулгүй сургууль арга хэмжээ, түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөө /2025-2028/" https://moe.gov.mn/post/166621, 5. Боловсролын сайдын 2025 оны А/224 дүгээр тушаалаар батлагдсан ”Сургуулийн соёл-суралцагчийн төлөвшлийг дэмжих үйл ажиллагааны удирдамж”ь https://moe.gov.mn/post/166620 төсөлд тус тус санал авах, батлагдсан эрх зүйн актыг хэрэгжүүлэх зөвлөмж, мэдээллээр хангах; 4. Иргэдээс ЗГ-ын иргэд олон нийттэй харилцах 11-11 төв, утсаар, биеэр хандсан өргөдөл, хүсэлтүүдэд холбогдох хууль журмын дагуу тухай бүрд мэдээлэл өгөх, иргэд болон мэргэжлийн байгууллагуудаас хүссэн лавлагаа, мэдээлэлд албан бичгээр хариу өгөх зэргээр ажиллалаа. | 100% | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 4.1.2 | Урт болон богино хугацааны бодлогын баримт бичиг, төсөл, хөтөлбөр, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг тайлагнах | - | Тайлангийн чанар, хугацаа, биелэлтийн хувь | 2024 оны гүйцэтгэлийн түвшингээр | 100 | 100 | Ерөнхий боловсролын газрын чиг үүрэгт хамаарах урт болон богино хугацааны бодлогын баримт бичиг, төсөл, хөтөлбөр, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг тухай бүрд тайлагнаж ажилласан. Үүнд: 1. Нэгжийн 14 хоног тутмын мэдээ, сар бүрийн тайлан 2. Ерөнхий сайдын албан даалгаварын хэрэгжилт 3. Хууль, тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн улирлар тутмын тайлан 4. Салбарын удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын биелэлт 5. Алсын хараа 2050, Улсын хөгжлийн жилтийн төлөвлөгөө, МУ-ыгн хөгжлийн 5 жилийн үндсэн чиглэл 6. Цаг үеийн шинжтэй үүрэг даалгавар, яамны бусад нэгжээс дотоод бичгээр ирүүлсэн холбогдох хууль, тогтоомж, шийдвэр, зөвлөмжийн хэрэгжилт, Засгийн газар болон бусад яамдаас шаардсан тайлан мэдээллийг тус тус нэгжийн хүрээнд нэгтгэн тайлагнаж ажиллалаа. | 100% | 100% |
| 4.1.3 | Авлигыг үл тэвчих ёс суртахууныг төлөвшүүлэх сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах, | - | Сургалтын тоо | Боловсролын сайдын 2024 оны 10 сарын 10-ны өдрийн А/137 дугаар тушаал | Хэрэгжилт хангагдсан байна. | Хэрэгжилт хангагдсан байна. | АТҮХ-ийн хүрээнд авилгыг үл тэвчих, шударга ёсны агуулга бүхий "Ес суртахууны хариуцлага" сургалтын дэмжих хөтөлбөрийг БСҮХ, АТГ хамтран боловсруулсаныг ЕБС-ийн 10 дугаар ангид багш зохицуулах цагийн хүрээнд хэрэгжүүлэх тухай тушаалын төслийг бэлтгэн албан хэрэг хөтлөлтийн системээр хянуулж, Боловсролын сайдын 2024 оны 10 сарын 10-ны өдрийн А/137 дугаар тушаалаар батлуулсан бөгөөд тус тушаалын хэрэгжилтийг хангах хүрээнд дараах байдлаар БЕГ-тай хамтран ажиллав. Үүнд: 1. АТҮХ-ийн хүрээнд АТГ, БСҮХ, БЕГ хамтран боловсруулж, туршин сайжруулж, батлуулсан тус сургалтыг дэмжих хөтөлбөр нь 6 цагийн агуулгын багтаамжтай бөгөөд хөтөлбөрийг 2024-2025 оны хичээлийн жилд өмчийн бүх хэлбэрийн ЕБС-ийн 10 дугаар ангид багш зохицуулах цагийн хүрээнд хэрэгжүүлсэн. 2. Боловсролын сайдын 2024 оны А/137 дугаар тушаалын дагуу “Ёс суртахууны хариуцлага” сургалтыг дэмжих хөтөлбөрийг 2024-2025 оны хичээлийн жилээс эхлэн өмчийн бүх хэлбэрийн ерөнхий боловсролын сургуулийн 10 дугаар ангид, ерөнхий боловсролын сургуулийн сургалтын төлөвлөгөөний багш зохицуулах цагийн хүрээнд хэрэгжүүлэхэд | 100% | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | дэмжлэг үзүүлэх сургалтыг аймаг, нийслэлийн ЕБС-ийн нийгмийн ухааны судлагдахууны 569 багшийг хамруулан БЕГ, БСҮХ, АТГ хамтран цахим хэлбэрээр зохион байгуулсан. 3. Ёс суртахууны хариуцлага сургалтыг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлэх багшид зориулсан арга зүйн зөвлөмжийг АТГ, БСҮХ хамтраан боловсруулж, ерөнхий боловсролын сургуулиудад түгээсэн. Тус зөвлөмжийг хэвлэх зардлыг АТГ-аас Авилгатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хүрээнд санхүүжүүлсэн.<br>Хавсралт: 1 файл | | |

*Үнэлсэн:* .........................

*..........................................* ......................... */................................/*

*(албан тушаал )* *(гарын үсэг)*

.........................

*(огноо)*

*Тайлагнасан:* .........................

*..........................................* ......................... */................................/*

*(албан тушаал )* *(гарын үсэг)*

.........................

*(огноо)*